



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 07 сарын 21 өдөр

Дугаар А/444

Эрдэнэт

Тусламж үзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орхон, Булган аймгийн нутаг дэвсгэрийн зарим хэсгээр 2017 оны 06 дугаар сарын 28-29-нд шилжих шөнө цаг агаарын аюулт үзэгдэл болж хүчтэй салхи, аадар бороо, мөндөр орсны улмаас их хэмжээний хохирол амссан Баян-Өндөр сумын Эрдэнэ багийн 46-41 тоотод оршин суух иргэн Б.Эрдэнэчимэгт 6м*10 метрийн хүлэмж 1 ширхэгийг, Онцгой байдлын газрын албан хаагчдын хэрэгцээнд 6м*20м хэмжээтэй хүлэмжнээс 1 ширхэгийг тус тус өрхийн тариалалтыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 50 хувийн хөнгөлөлттэй олгож байсан ногоо тарих хүлэмжнээс 100 хувийн хөнгөлөлттэй нөхцөлөөр олгосугай.
2. Дээрх нэр бүхий иргэдэд нийлэг хальсан бүрхүүлтэй зуны хүлэмжийг заагдсан тоо, хэмжээгээр олгохыг Хүнс, хөдөө, аж ахуйн газар /н.Бат-Өлзий/-т зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Ш.Ганболдод даалгасугай.



С.БАТЖАРГАЛ